



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 1/25

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монголын Улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 09/02 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн 3.6.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын Улаан загалмай нийгэмлэгийн 80 жилийн ойн арга хэмжээний хүрээнд Ерөнхий нарийн бичгийн газар, дунд шатны хорооны удирдах зөвлөл, ажилтнуудын урлаг спортын наадамд 350000 (гурван зуун тавин мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын хичээл үйлдвэрлэлийн зардлаас гаргахыг нягтлан бодогч (О.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

012100091

D: My Doc. Tushaal. ZDTG